


БАТЛАВ.  
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА




Ж.ЦОЛМОН

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ ГАРГАХ,  
ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-12		
Баталсан огноо:	2025 он- 11 сар- 30 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр Х. Каракзун	Огноо 2025.11.29	Гарын үсэг 
Боловсруулсан:	Албан тушаал, нэр Н. Бэрэнчимэл	Огноо 2025.11.29	Гарын үсэг 

### Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Шинэ хууль, дүрэм	Бүгд	Шинжлэн шалгагч	2025. 11.30	
2					
3					

### Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Журам	Шинжлэн шалгагч нарт
2		
3		

## АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ ГАРГАХ, ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба/АХОЗШША/-аас Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгасан тайланг үндэслэн Аюулгүй байдлын зөвлөмж гаргах /цаашид Зөвлөмж гэх/, Аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийн явц, биелэлтэнд үнэлгээ хийх, үр дүнг дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Үнэлгээний зорилго нь иргэний нисэхийн аюулгүй байдал, нислэгийн аюулгүй ажиллагаа түүнд хандах хандлага, хариуцлагын тогтолцоог сайжруулахад оршино.

1.3. Энэ журам нь Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, Чикагогийн конвенцийн Хавсралт 13, түүний холбогдох баримт бичгүүд, Зам, тээврийн асуудал эрхэлсэн сайдын баталсан “Зам, тээврийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” болон Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн хүрээнд зохицуулагдана.

1.4. Зөвлөмж гадаад улсын байгууллага хэрэгжүүлэхээр гарсан бол түүний хэрэгжилтийг дүгнэх ажиллагааг энэхүү журмаар бус Олон улсын гэрээ хэлцлийн дагуу зохицуулна.

1.5. Нэн даруй хэрэгжүүлэх Зөвлөмжийн хэрэгжилтийг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмээр зохицуулна.

### Хоёр. Аюулгүй байдлын зөвлөмж гаргах

2.1. Иргэний нисэхийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдлын зөвлөмж гаргана.

2.2. АХОЗШША нь шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

2.3. Аюулгүй байдлын зөвлөмжийг агаарын хөлөг үйлдвэрлэгч, иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, агаарын тээвэрлэгч болон бусад холбогдох байгууллагад, шаардлагатай бол Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүргүүлнэ.

2.4. Шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайлан гаргахаас өмнө аюулгүй байдлын зөвлөмж гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж болно.

2.5. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн 90 хоногийн дотор эргэж мэдэгдэх бөгөөд хэрэгжүүлэх боломжгүй бол үндэслэл бүхий тайлбарыг гаргаж хүргүүлнэ.

2.6. Энэ журмын 2.4-т заасан этгээд аюулгүй байдлын зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх бодит үндэслэл байгаа бол тайлбарыг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ ГАРГАХ, ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ  
**Гурав. Үнэлж, дүгнэх ажлын зохион байгуулалт**

3.1. Аюулгүй байдлын зөвлөмж нь түүний хэрэгжилтийн зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааны болон техникийн технологи ажиллагааг тодорхойлдоггүй тул анх хүлээн авсан байгууллага нь зөвлөмжийг хэрхэн, хэдий хугацаанд хэрэгжүүлэх талаар бодит төлөвлөлтийг аль болох богино хугацаанд гаргаж нэн даруй АХОЗШША-д мэдэгдэнэ.

3.2. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан байгууллага нь улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор зөвлөмжийн биелэлт, хэрэгжилтийн тайланг гаргаж албанд ирүүлсэн байна.

3.3. Аюулгүй байдлын зөвлөмжийн биелэлт, хэрэгжилтийн тайлан нь үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэсэн ажлын чанарыг бүрэн, тодорхой илэрхийлсэн байх ба тайлангийн үнэн зөв, байдлыг байгууллагын удирдлага хариуцна.

3.4. Алба нь аюулгүй байдлын зөвлөмжийн биелэлт, хэрэгжилтийн тайланг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт үнэлж, дүгнэх ажлыг зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагуудтай дүгнэх ажиллагааг хамтарч зохион байгуулна.

3.5. Алба нь аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг нэгтгэн, үнэлж дүгнэн, улирал бүр тайланг ЗТЯ-нд хүргүүлсэн байна.

**Дөрөв. Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний аргачилал**

4.1. Аюулгүй байдлын зөвлөмж /цаашид зөвлөмж гэх/ хэрэгжилтийг үнэлэхдээ журмын хавсралтыг баримтлан зөвлөмж нэг бүрийн гүйцэтгэлийг өссөн дүнгээр гаргаж, хувиар илэрхийлж дүгнэнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасны дагуу үнэлгээний хувийг тодорхойлохдоо зөвлөмж тус бүрд төлөвлөгөөт хугацаа болон ажлын чанараас хамаарч дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

4.2.1. Энэ журмын 3.1-д заасан хугацаанд зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх ажиллагаа хийгдэхгүй.

4.2.2. “Бүрэн хэрэгжсэн” - Зөвлөмжийг хугацаанд нь чанартай бүрэн хэрэгжүүлсэн, холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

4.2.3. “Хэрэгжих шатанд” – Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

4.2.4. “Хэрэгжилт хангалтгүй” – Зөвлөмжийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-49 хувь).

4.2.5. “Хэрэгжээгүй” - Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй, энэ журмын 3.1-д заасан хугацаанд хэрхэн хэрэгжүүлэх талаар хариу ирүүлээгүй бол 0 хувь (0-9 хувь).

4.2.6. “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”.

4.2.7. Зөвлөмжийн хэрэгжилт нь хүндэтгэн үзэх шалтгаанаар төлөвлөсөн завсрын хугацаанаас хэтэрсэн бол удааширсан буюу өмнөх үнэлгээг хадгалж үлдэнэ.

4.2.8. Зөвлөмжийн хэрэгжилт нь хүндэтгэн үзэх шалтгаангүй төлөвлөсөн завсарын хугацаанаас хэтэрсэн бол удааширсан буюу өмнөх үнэлгээг 1 шат бууруулан үнэлнэ.

4.2.9. Хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзвэл зөвлөмжийн хэрэгжилтийн дуусах хугацааг дахин тогтоож болно. Энэ тохиолдолд өмнөх үнэлгээ хадгалагдаж үлдэнэ.

4.2.10. Алба нь тухайн биелэлтийг холбогдох шалгуурын дагуу үнэлэхдээ ажлын чанараас хамааран 1 шатаар өсгөх буюу бууруулж үнэлж болно.

4.2.11. Зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлээгүй бол тухайн арга хэмжээг өмнөх улирлын дүнгээр үнэлнэ.

#### **Тав. Аюулгүй байдлын зөвлөмжийн биелэлт, хэрэгжилтэнд тавих үнэлгээний зарчим**

5.1. Аюулгүй байдлын зөвлөмжийн биелэлт, хэрэгжилтэнд үнэлгээ хийхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Шударга, хараат бус байх;
- Үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод байх;
- Үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- Үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүнг тодорхойлсон, нотлогдохуйц байх
- Үнэлгээг тасралтгүй, тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;
- Үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцдаг байх.

5.2. Үнэлгээний тайланд иргэний нисэхийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц болон нислэгийн аюулгүй ажиллагааг сайжруулахад дэмжлэг болох саналыг тусгасан байна.

5.3. Үнэлгээний тайлангийн дүгнэлтэд үндэслэн тухайн зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт санал оруулах, хүчингүй болгох болон

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ ГАРГАХ, ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ  
шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг ахлах шинжлэн шалгагч  
хариуцан зохион байгуулна.

5.4. Тухайн жилд хийсэн зөвлөмжийн биелэлт, хэрэгжилтийн үнэлгээний  
ажлын тайланг холбогдох журмын дагуу архивын нэгж болгон бүрдүүлж, дараа  
оны нэгдүгээр улиралд багтаан оператор, туслах ажилтанд хүлээлгэн өгнө.

### **Зургаа. Хариуцлага**

6.1. Алба нь зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний дүнгээр хагас, бүтэн  
жилээр дараалан хангалтгүй үнэлгээ авсан, хэрэгжилтэнд хариуцлагагүй  
хандсан байгууллагын удирдлагын талаар эрх бүхий албан тушаалтанд  
уламжилна.

6.2. Дараах зөрчил гаргасан албан тушаалтанд Төрийн албаны тухай,  
Төсвийн тухай болон холбогдох бусад хууль, Байгууллагын дотоод журамд  
зааснаар хариуцлага хүлээлгэнэ. Үүнд;

6.2.1. Энэхүү журмыг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан;

6.2.2. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүндэтгэн үзэх шалтгаангүй  
биелэлтэд саад учруулсан, биелүүлээгүй;

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ҮНЭЛЭХ АРГАЧИЛАЛ

№	Аюулгүй байдлын зөвлөмжүүд	Хүрэх түвшингийн тодорхойлолт	Тухайн ажлын хэрэгжилтийн түвшингийн үнэлгээнд хамаарах үе шат			
			0%	30%	70%	100%
1	ЗӨВЛӨМЖ/01					
2	ЗӨВЛӨМЖ/02					
3	ЗӨВЛӨМЖ/03					

-----oOo-----